Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Боловсролын салбарын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Гантулга Наранбаатар

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, санал өгөх, хэрэгжилтийг хангуулахад мэргэжил арга зүйгээр хангах | | | | | | | |
| 1 | Боловсролын хууль тогтоомж, дүрэм журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэх хяналтын хуудсыг боловсруулж батлуулах | Хяналтын хуудас боловсруулж батлуулсан байна. | 1 | - | - Боловсролын ерөнхий хууль болон хамт өргөн мэдүүлсэн хууль эцэслэн батлагдсантай холбогдуулан 03/6.1-4 кодтой "Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас"-ыг Дээд боловсролын газар, Хууль, эрх зүйн хэлтэс болон аймаг, нийслэлийн улсын байцаагчдаар хэлэлцүүлэн санал авч, хуульд нийцүүлэн шинээр дахин боловсруулж, БШУ-ны сайдын 2024 оны 04 сарын 02-ны өдрийн "Хяналтын хуудас | 3-р сар, 4-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинэчлэн батлах тухай" А/150 дугаар тушаалаар баталсан. Тус хяналтын хуудсаар 2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдахаар зарлагдсан дээд боловсролын сургалтын байгууллагын эрсдэлийг үнэлэн ашиглаж байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.2. Иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх | | | | | | | |
| 2 | Ерөнхий боловсролын сургууль болон дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчны стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийнэ. | Стандартын хэрэгжилтийн хувь Илэрсэн зөрчлийн эзлэх хувь | Стандартын хэрэгжилтийн хувь - 47.5% Илэрсэн зөрчлийн эзлэх хувь - 33,4% | Стандартын хэрэгжилтийн хувь - 52,5% Илэрсэн зөрчлийн эзлэх хувь - 28,4% | Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчны стандартын нөхцөл шаардлагын хэрэгжилтэд хийх хяналт шалгалтыг БШУ-ны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай" А/50 дугаар тушаалаар батлагдсан Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх удирдамжид заасан аргачлалын дагуу төрийн болон төрийн бус өмчийн 77 их, дээд сургуульд шалгуур үзүүлэлтэд туссан сургалтын орчны нөхцөл байдлыг үнэлж, тайлан, тоон мэдээллийг | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 85%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэгтгэн боловсруулж, Боловсролын үнэлгээний төвд дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбийн мэдээлийг гаргуулахаар хүргүүлсэн.<br>Хавсралт: 3 файл | | |
| 3 | Боловсролын багц хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох санал өгнө. | Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо | 4 | 2 | Боловсролын багц хуулийг дагаж гарах боловсролын сургалтын байгууллагад холбогдох шинэчилсэн дүрэм, журам болон бусад холбогдох хуулийн төсөлд санал өгч ажилласан. Тухайлбал аймаг, нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газрын ажиллах журмын төсөлд 2 санал, Дээд боловсролын сургалтын байгууллагад холбогдох цахим бүртгэлийн шинэчилсэн журмын төсөлд 3 санал, Боловсролын яамны дотоод журмын төсөлд 1 санал, Зөрчлийн тухай хуульд боловсролын хяналтын чиглэлээр оруулах 6 санал, Зөвшөөрлийн тухай хуульд оруулах 3 санал өгч ажиллалаа.<br>Хавсралт: 3 файл | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Их буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | Шалгалт хийсэн объектын тоо Зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин | - | Шалгалт хийсэн объектын тоо - 3 Зөрчил арилгуулалтын хувь - 35% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 40% | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 420 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай” А/15 дугаар тушаал, БШУЯ-ны Салбарын улсын ерөнхий байцаагч, ЭМЯ-ны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 03-00/03 дугаартай удирдамжийн хүрээнд 2024 онд Салбарын хяналтын газраас төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр зарлагдсан ҮБХИС, Шинэ монгол технологийн дээд сургууль, Хүрээ мэдээлэл, холбоо технологийн дээд сургууль, МУИС-ийн Ховд аймаг дахь Баруун бүсийн сургууль, Дархан-Уул аймаг дахь Дархан дээд сургуулийн сургалтын үйл ажиллагаанд төлөвлөгөөт | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 95%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хяналт шалгалт хийж, хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэн Төрийн хяналт шалгалтын тухай, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай, Зөвшөөрлийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталсан захиргааны хэм хэмжээний акт, стандартын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч, Улсын байцаагчийн 54 заалт бүхий 5 албан шаардлагаар зөрчил арилгуулах хугацаатай үүрэг өгч, хяналт шалгалтын мэдээллийг шилэн хяналтын цахим системд бүрэн оруулж ажиллалаа.<br>Хавсралт: 3 файл | | |
| 5 | Элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Зөрчил арилгуулалтын хувь | Зөрчил арилгуулалтын хувь - 60% | - | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 420 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Журам батлах тухай” А/66 дугаар тушаалаар баталсан “Элсэлтийн шалгалт зохион байгуулах журам”, | 7-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 80%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2024 оны А/20 дугаар тушаалын хавсралтаар баталсан “2024 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын удирдамж”-ийн хүрээнд 2024 оны Элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулалт, орон нутагт их, дээд сургуулиудын хуваарь сонгох үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Босго оноо тогтоох тухай” А/170 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр нийслэл, аймгийн Боловсролын газрын улсын байцаагчдад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.<br>Хавсралт: 1 файл | | гүйцэтгэсэн байдал: 100% |
| 6 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь Зөрчил арилгуулалтын | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 90% Зөрчил | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 90% Зөрчил арилгуулалтын | - БШУ-ны сайдын 2024 оны А/50 дугаар тушаалаар баталсан "Дээд боловсролын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх | хувь | арилгуулалтын хувь - 95% | хувь - 70% | сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх", БШУ-ы сайдын 2024 оны А/212 дугаар тушаалаар баталсан "Ажлын хэсэг байгуулах, дүгнэлт гаргах" удирдамжийн хүрээнд нийт 77 дээд боловсролын сургалтын байгууллагад эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, цаашид авах хэмжээний санал дүгнэлт боловсруулан танилцуулсан. - Боловсролын сайдын 2024 оны А/216 дугаар тушаалаар баталсан "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай" удирдамжийн хүрээнд Ерөнхий боловсролын 12 сургуулийн удирдлагын систем (SMS), суралцахуйн удирдлагын систем (LMS)-ийн суурилуулалт, нэвтрүүлэлт, ашиглалт, хэрэгжилт, үр дүнд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, цаашид авах хэмжээний санал дүгнэлт боловсруулан танилцуулсан. - СХГ-ын | сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | даргын баталсан 2024 оны "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 03-00/30, "ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 03-00/33, "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 03-00/34 дүгээр удирдамжийн хүрээнд хяналт шалгалт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан танилцуулж ажилласан. - Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 40 албан бичиг, 28 хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авч, 76 иргэний боловсролын баримт бичигт шалгалт хийж, 24 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 4 өргөдөл гомдол, 2 албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг харъяаллын дагуу шилжүүлж, нийт хариутай 30 албан бичгээр хариу өгч, албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажилласан.<br>Хавсралт: 6 файл | | |
| 7 | Өмнөх шалгалтын | Албан | Албан | Албан | БЯ-ны Салбарын улсын | 9-р сар, | Өөрийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх | шаардлагын тоо Зөрчил арилгуулалтын хувь | шаардлагы тоо - 1 Зөрчил арилгуулалтын хувь - 55% | шаардлагын тоо - 5 Зөрчил арилгуулалтын хувь - 60% | ерөнхий байцаагч, ЭМЯ-ны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 03-00/03 дугаартай удирдамжийн хүрээнд 2024 онд Салбарын хяналтын газраас төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр зарлагдсан ҮБХИС, Шинэ монгол технологийн дээд сургууль, Хүрээ мэдээлэл, холбоо технологийн дээд сургууль, МУИС-ийн Ховд аймаг дахь Баруун бүсийн сургууль, Дархан-Уул аймаг дахь Дархан дээд сургуулийн сургалтын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт, хийж, хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэн Төрийн хяналт шалгалтын тухай, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай, Зөвшөөрлийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталсан захиргааны хэм хэмжээний акт, стандартын хэрэгжилтийг хангуулахаар Улсын байцаагчийн 54 заалт бүхий 5 албан | 10-р сар, 11-р сар, 12-р сар | үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 85%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шаардлагаар зөрчил арилгуулах хугацаатай үүрэг өгч, хяналт шалгалтын мэдээллийг шилэн хяналтын цахим системд бүрэн оруулж ажилласан. СХГ-ын даргын баталсан 2024 оны "ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 03-00/33 дугаар удирдамжийн хүрээнд хяналт шалгалт хийж, Улсын байцаагчийн 4 заалт бүхий албан шаардлагаар зөрчил арилгуулах үүрэг даалгавар өгч ажилласан.<br>Хавсралт: 6 файл | | |
| 3.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах | | | | | | | |
| 8 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан боловсруулах. | Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт боловсронгуй болсон байна. | 2 | 1 | - Төрийн албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг Боловсролын яамны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Салбарын хяналтын газрын 2024 оны төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж,төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөөг нэгжийн даргаар батлуулан, биелэлтийг сар бүр, хагас жил, бүтэн жилээр тайлагнаж байна. | | хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 9 | Цаг үеийн нөхцөл шаардлагаар хийж хэрэгжүүлэх ажил үйлчилгээг гүйцэтгэх | Хэрэгжүүлсэн арга хэмжээ Гүйцэтгэлийн хувь | - | Хэрэгжүүлсэн арга хэмжээ – 100 Гүйцэтгэлийн хувь - 100% | - Боловсролын ерөнхий хууль болон хамт өргөн мэдүүлсэн хууль эцэслэн батлагдсантай холбогдуулан Дээд боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг Дээд боловсролын удирдлага, зохицуулалтын газар, хууль, эрх зүйн хэлтэс болон аймаг, нийслэлийн улсын байцаагчдаар хэлэлцүүлэн санал авч, хуульд нийцүүлэн шинээр дахин боловсруулж, БШУ-ны сайдын 2024 оны 04 сарын 02-ны А/150 тоот тушаалаар баталлаа. - БШУ-ны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/50 дугаар тушаалаар байгуулагдсан Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх ажлын хэсгийн нарийн бичгийн дарга - БШУ-ны сайдын 2024 оны "Магадлан шалгах ажлын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэсэг байгуулах тухай" А/127 дугаар тушаалаар байгуулагдсан зөвшөөрөл олгоход хуульд заасан шаардлага хангаж байгаа эсэхийг магадлан шалгах ажлын хэсэг - БШУ-ны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах, дүгнэлт гаргах тухай" А/212 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг -Боловсролын сайдын 2024 оны "Хамтарсан ажлын хэсгийн Монголын талын бүрэлдэхүүнийг батлах тухай" А/210 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг - Боловсролын сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай" А/216 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн нарийн бичгийн дарга - БЯ-ны ТНБД-ын 2024 оны "Спортын зөвлөл шинэчлэн байгуулах тухай" А/44 дүгээр тушаалаар байгуулсан зөвлөлийн бүрэлдэхүүн - Төрийн албаны зөвлөлийн Боловсролын яамны Салбар зөвлөлийн 2024 оны 11 сарын 07-ны өдрийн 48 дугаар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоолоор баталсан ажлын хэсгийн нарийн бичгийн дарга - БЯ-ны СХГ-ын даргын баталсан "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 03-00/34 дугаартай удирдамжийн ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажилласан.<br>Хавсралт: 10 файл | | |
| 10 | Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь мэдүүлэх | Төрийн албан хаагчийн ХАСХОМ ил тод, хуульд заасан хугацаанд мэдүүлсэн байна. | 1 | - | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргаж, холбогдох эрх бүхий албан тушаалтанд тайлагналаа. | 1-р сар, 2-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин |
|---|---|---|---|

| | хэрэгжүүлэх арга хэмжээ | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Төрийн албаны болон салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн шинээр болон шинэчлэн батлагдсан дүрэм журмыг уншиж судлах | Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг тухай бүр уншиж, судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. | - | Албан хаагчийн хууль эрх зүйн мэдлэг сайжирсан байна. | Боловсролын яамны бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль болон хамт батлагдан гарсан боловсролын багц хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон шинэчлэгдэн гарсан холбогдох дүрэм журмын талаар уншиж судлан, хяналт шалгалтын үйл ажиллагаанд тусган ажиллаж байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% |
| 2 | Мэргэжил, боловсролоо дээшлүүлэх чиглэлээр танхимын болон цахим сургалтуудад хамрагдана. | Мэргэжил, боловсролоо дээшлүүлэх чиглэлээр танхимын болон цахим сургалтуудад хамрагдана. | - | Албан хаагчийн хууль эрх зүйн мэдлэг сайжирсан байна. | -Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (шилэн хяналт) ашиглалтад орж байгаатай холбогдуулан хяналтын улсын байцаагч нарт зориулсан цахим сургалтанд хамрагдсан. -Аймаг, нийслэлийн Боловсролын хяналтын улсын /ахлах/ байцаагчдад зориулсан хяналт шалгалтын арга зүй, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэглээ сэдэвт сургалтад хамрагдсан. -НПГ-аас зохион байгуулсан Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шийдвэрлэх тухай хуулийн хэрэглээ, анхаарах асуудлын талаар "ЗӨРЧИЛ, ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА, ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ПРАКТИК ШААРДЛАГА, ХУУЛИЙН ХЭРЭГЛЭЭ" сэдэвт сургалтад хамрагдсан. -Байгууллагын 7 хоног бүр зохион байгуулж буй мэдээллийн цагт бүрэн хамрагдаж, холбогдох мэдээ мэдээллийг авч байна | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Боловсролын салбарын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Гантулга Наранбаатар /................................................../
Огноо: ........................